



БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН 4-Р БАГИЙН НУТАГТ БАРИГДАХ МАХНЫ  
ҮЙЛДВЭРИЙН ЦОГЦОЛБОРЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024.04.10

№ 35-06/2024

Булган сум

1.	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	Булган аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх "Шинэ хөгжлийн зам" хөтөлбөр
2.	Барилга байгууламжийн нэр, байршил, хүчин чадал, үзүүлэлт:	Булган аймгийн Булган сумын 4-р багийн нутагт 1,5 га-д хамран баригдах махны үйлдвэрийн барилга байгууламж
3.	Захиалагч	Булган аймгийн ЗДТГ
4.	Эдэлбэр газрын тухай	Булган аймгийн Засаг даргын 2018 оны 03 сарын 02-ны өдрийн А/136 дугаар захирамжаар Булган сумын Рашаант 4-р баг, Домын дэвсэг-15 гудамжны 1501 тоотод ХАА-н үйлдвэрлэлийн зориулалтаар ХХААХҮ-ийн яаманд 91302 м <sup>2</sup> газрыг олгосон бөгөөд үүний 1,5 га нь махны үйлдвэрийн чиглэлээр ашиглагдана.
5.	Дагаж мөрдөх ерөнхий төлөвлөгөө, бүсчлэл	Булган сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, үйлдвэржилтийн бүс
6.	Захиалагчаас нийлүүлэх баримт бичгүүд	-Архитектур-төлөвлөлтийн даалгавар -Барилгын ачаалалд нийцсэн техникийн нөхцлүүд
7.	Барилгажих талбай	Махны үйлдвэрийн барилгын барилгажих талбай довжоог оролцуулаад 990 м <sup>2</sup> Бусад туслах байгууламжууд
8.	Архитектур төлөвлөлтийн шаардлага	Гол хаалганд талбайг төлөвлөж гадуур нь гэрэлтүүлэгтэй ногоон байгууламж бүхий амрах бүс төлөвлөсөн байна. Махны үйлдвэрийн хашааны дотор байх бусад байгууламжуудыг үүргийн зориулалтаар нь тусгайлан замаар холбох бөгөөд цэвэрлэх байгууламж хогийн цэгийг салхины доор төлөвлөх
9.	Барилгын эзлэхүүн төлөвлөлт	Махны үйлдвэрийн барилга нь Гонх, хүлээлгийн өрөө, оффисийн өрөөнүүд, малын эмчийн өрөө, хуйсийн ялгаатайгаар хувцас солих болон ариун цэврийн болон усанд орох өрөөнүүдтэй байна. Гал тогоо болон хооллох танхим байх ба бод ба бог малыг өөр өөр хаалгаар оруулах бөгөөд түүнд залбирал үйлдэх, цуслах, толгой шийр таслах, арьс хуулах, дотор эрхтэн авах, цааш угаалга хийх, сэврээх өрөөнүүдтэй байна. Цуллаг эрхтэн, арьс цус, толгой шийр бэлтгэх өрөөнүүд болон сэвс



		цэвэрлэх, цуллаг эрхтэн сэврээх, хөлдөөх өрөөг төлөвлөх ба бод, богийн аль альны шугамд 2-оос доошгүй хөлдөөх камерийг төлөвлөх ба мөн тус бүрд нь шулалгаа-ангилган ялгах өрөөнүүдийг төлөвлөх Мөн хөлдүүгээр хадгалах зоорийг төлөвлөх бөгөөд худалдаан гаргах хаалгыг гарсан байна. Уг барилгад дулааны болон цахилгааны өрөөг заавал төлөвлөх
10.	Инженерийн шугам сүлжээ, түүнийг хангах эх үүсвэр:	Цэвэр ус –бие даасан Бохир ус – бие даасан Хэрэгцээний халуун ус – бие даасан Цахилгаан-техникийн нөхцлөөр Дулаан- бие даасан Холбоо, дохиолол- техникийн нөхцлөөр
11.	Зураг төслийн үе шат:	Зураг төсөл 2-үе шаттай байна. -загвар зураг -ажлын зураг төсөл
12.	Зургийн байгууллага:	Холбогдох тусгай зөвшөөрөл бүхий барилгын зураг төслийн байгууллага
13.	Ажлын зургийг гүйцэтгэх хугацаа:	Гэрээгээр зохицуулна.
14.	Барилгын шийдэл бүтэцийн	Барилга нь "Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх" БНБД 22-01-21, Ган бүтээц БНБД53-03-22, Ган бүтээцийн зураг төсөл боловсруулах дүрэм MNS2560:2013 норм стандартын шаардлагыг хангасан металл араг бүтээцтэй байна
15.	Гадна тохижилт	"Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД-30-01-04-ийн дагуу төлөвлөх ба барилгын гол хаалганы өмнөх талбайд гэрэлтүүлэг бүхий талбай төлөвлөх
16.	Инженерийн бэлтгэл арга хэмжээ, Өндөржилтөнд тавигдах шаардлага	Барилгын байршлын болон барилгын дээврээс урсах гадаргуугийн урсацыг орчны барилгуудын байршилтай уялдуулан өндөржилтийн шаардлагатай түвшинг бий болгох урсган зхйлуулах арга хэмжээ авах
17.	Галын аюулгүй байдлын шаардлага	Хот тосгоны төлөвлөлт, барилгажилт БНБД 30-01-21-ийн 4-р хавсралт, "Барилга байгууламжийн галын аюулгүй байдал" БНБД-21-01-02, "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНБД 21-02-02, "Барилга байгууламжийн гал унтраах автомат тоног төхөөрөмж, дохиоллын хэрэгсэл" БНБД 21-04-т заагдсан шаардлагыг хангасан байна.




18.	Барилгын улаан шугам	Хот тосгоны улаан шугамыг төсөллөх заавар" УББ 30-202-11-ийг нягт мөрдөн ажиллах
19.	Онцгой нөхцөл:	Газар хөдлөлтийн 8 баллын бүст оршдог. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан бүхий л арга хэмжээг норм дүрмийн дагуу зураг төсөлд тусгана.
20.	Барилга угсралтын ажлыг гүйцэтгэх хугацаа	Дулааны улиралд

**Жич анхааруулах нь:**

1. Барилга байгууламжийг шинээр төлөвлөхөд энэхүү архитектор-төлөвлөлтийн даалгаварт заасан нэр, зориулалт, категориыг өөрчлөхийг хориглоно.
2. Зайлшгүй өөрчлөх шаардлага гарсан тохиолдолд ГХБХБГ-аас албан ёсны зөвшөөрөл авсан байвал зохино.
3. Зураг төслийн зохиогч нь даалгаварт тусгагдсан өгөгдлийн дагуу төлөвлөлт хийхдээ барилга баригдах байршлын одоогийн байдалтай сайтар танилцаж, судалсан байвал зохино.

**БОЛОВСРУУЛСАН:**

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
 БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
 ДАРГА  Б.ГАНЗОРИГ